



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШИНГЭН ТУЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ БАЙГУУЛАМЖ ТӨРИЙН ӨМЧИТ
АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2023/75/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261205 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Аудитор: Ж.Энхтуяа
Утас: Цахим хаяг: enkhtuyaaj@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Уваа уул Аудит ХХК-ийн
захирал Ч.Мөнхтуяа
Утас: 99108763 Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com

Улаанбаатар хот
2023 он

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	10
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар	14
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.3 Зөвлөмж	15
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

ААНБОАТ	Аж ахуй нэгж байгууллагын орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ГТБ	Газрын тосны бүтээгдэхүүн
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СНАГ	Санхүү-нийцлийн аудитын газар
СТОУС	Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ҮХХАТ	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ШТШАБ	Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг

Бага тойруу-3, Засгийн газрын IV байр

Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30

E-mail: info@audit.gov.mn

ГШИНГЭН ТУЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ
БАЙГУУЛАМЖ ТӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Г.ГАНСУХ ТАНАА

2023.03.15 № 07/546
танай -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ЫН 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлзээ.

Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ЫН 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайллагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохицтой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийт орлогын гүйцэтгэл 2,125.0 сая төгрөг болж төлөвлөснөөс 761.9 сая төгрөг буюу 17.5 хувиар буурсан нь шилжүүлэн ачилтын импортын хэмжээ буурч, хадгалалтын үйл ажиллагааны гол хэрэглэгч болох Лекс Ойл ХХК нь ижил төрлийн үйл ажиллагаа явуулж эхэлсэнтэй холбоотой байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд орлогыг 4,341.8 сая төгрөгөөр, зардлыг 2,739.9 сая төгрөг, цэвэр ашгийг 1,441.8 сая төгрөг байхаар баталсан байна. Гүйцэтгэлээр 3,579.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,125.0 сая төгрөгийн зардал гарган, 1,307.3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай байгуулсан контрактын биелэлтийн шалгуур үзүүлэлтээр 1 зорилтын хүрээнд 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлгагасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээн үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Няглан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залilan эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залilan эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залilan эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн здийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Ж.ЧНАРАНЧИМЭГ*

АТД9603 9006109
9023000583

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	1,401,789,382.69	4,847,081,366.00
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	136,122,443.96	284,290,780.21
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	6,856,404,752.77	3,252,857,336.94
1.1.6	Бараа материал	260,832,219.43	250,925,839.72
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	31,922,547.73	24,552,800.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	8,687,071,346.58	8,659,708,122.87
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	12,667,709,150.82	13,214,047,975.56
1.2.2	Биет бус хөрөнгө	1,380,021,532.52	1,386,878,576.94
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	14,047,730,683.34	14,600,926,552.50
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	22,734,802,029.92	23,260,634,675.37
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	8,641,978.00	33,784,545.12
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	28,056,925.85	12,577,184.05
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	36,698,903.85	46,361,729.17
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	107,532,962.97	107,532,962.97
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	107,532,962.97	107,532,962.97
2.2	Өр төлбөрийн нийт дүн	144,231,866.82	153,894,692.14
2.3	Эздиин өмч		
2.3.1	Төрийн өмч	15,362,339,049.32	15,362,339,049.32
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	282,110,305.92	535,186,521.93
2.3.9	Хуримтлагдсан ашиг	6,946,120,807.86	7,209,214,411.98
2.3.11	Эздиин өмчийн дүн	22,590,570,163.10	23,106,739,983.23
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	22,734,802,029.92	23,260,634,675.37

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	4,169,440,269.97	2,921,231,086.37
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	4,169,440,269.97	2,921,231,086.37
5	Хүүгийн орлого	647,225,895.72	657,895,892.18
8	Бусад орлого	350,000.00	805,000.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,805,176,568.30	2,103,047,511.09
12	Бусад зардал	100,124,920.00	5,582,410.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	(16,340,792.73)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	2,911,714,677.39	1,454,961,264.73
19	Орлогын татварын зардал	301,219,467.74	147,669,576.75
20	Татварын дараах ашиг (алдагдал)	2,610,495,209.65	1,307,291,687.98
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	2,610,495,209.65	1,307,291,687.98
24	Орлогын нийт дүн	2,610,495,209.65	1,307,291,687.98
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	15,362,339,049.32	282,110,305.92	4,614,138,485.05	20,258,587,840.29
Залруулсан үлдэгдэл	15,362,339,049.32	282,110,305.92	4,614,138,485.05	20,258,587,840.29
Зарласан ногдол ашиг	-	-	278,512,886.84	278,512,886.84
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	2,610,495,209.65	2,610,495,209.65
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	15,362,339,049.32	282,110,305.92	6,946,120,807.86	22,590,570,163.10
Залруулсан үлдэгдэл	15,362,339,049.32	282,110,305.92	6,946,120,807.86	22,590,570,163.10
Зарласан ногдол ашиг	-	-	1,044,198,083.86	1,044,198,083.86
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			1,307,291,687.98	1,307,291,687.98
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	253,076,216.01
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	15,362,339,049.32	535,186,521.93	7,209,214,411.98	23,106,739,983.23

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,609,905,413.00	3,250,098,651.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,586,698,312.00	3,213,354,195.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	23,207,101.00	36,744,456.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,028,603,013.98	2,025,688,941.01
1.2.1	Ажилдагсад төлсөн	676,560,262.00	761,606,539.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	199,445,701.74	226,603,562.62
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	57,052,759.57	63,550,906.55
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	54,646,907.90	54,810,338.08
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	65,080,061.00	81,788,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	697,676,614.43	605,015,795.18
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	118,800.00	199,050.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	278,021,907.34	232,114,749.58
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,581,302,399.02	1,224,409,709.99
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,482,225,895.72	9,777,267,946.97
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	835,000,000.00	9,119,372,054.79
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	647,225,895.72	657,895,892.18
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,351,910,151.96	6,512,187,589.79
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	690,232,601.63	978,093,155.37
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	25,205,454.54	18,269,795.46
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	2,636,472,095.79	5,515,824,638.96
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,869,684,256.24)	3,265,080,357.18
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	278,512,886.84	1,044,198,083.86
3.2.4	Төлсөн ногдол ашиг	278,512,886.84	1,044,198,083.86
3.2.5	Валютын ханшийн тэгшигтгэлийн алдагдал	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(278,512,886.84)	(1,044,198,083.86)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	433,105,255.94	3,445,291,983.31
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	968,684,126.75	1,401,789,382.69
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,401,789,382.69	4,847,081,366.00

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж төрийн өмчит аж ахуйн тооцoot үйлдвэрийн газрын
2022 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	Хэмжи х нэгж	2021	2022		Зөрүү	Хувь
			гүйцэтгэл	Төлөвлөгөө	гүйцэтгэл		
	<u>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, түгээлт борлуулалт</u>						
	a/ Гол нэр төрлөөр						
1	Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих	тонн	126,690.7	75,600.0	68,638.5	6,961.53	90.8
	Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах	тонн	18,750.0	12,700.5	9,690.5	3,009.98	76.3
2	Нийт орлого	мян.төг	4,817,016.2	4,341,817.9	3,579,932.0	761,885.9	82.5
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	4,156,344.3	3,621,817.9	2,921,231.0	708,967.3	80.4
	Дансны хүү, ГТБ шинжилгээний орлого	мян.төг	660,671.9	720,000.0	658,701.0	52,918.6	92.7
3	Нийт зардал	мян.төг	1,905,301.5	2,739,865.4	2,124,970.7	614,894.7	77.6
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	411,265.2	493,006.2	298,152.0	194,854.2	60.5
4	Татварын өмнө ашиг	мян.төг	2,911,714.7	1,601,952.5	1,454,961.3	146,991.2	90.8
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	2,610,495.2	1,441,757.3	1,307,291.7	134,465.6	90.7
	<u>төсвийн төлбөрт нийт дүн</u>	мян.төг	831,931.4	752,700.8	740,028.9	12,671.9	98.3
	ААНОАТ-т	мян.төг	139,301.8	160,195.3	189,501.6	(29,306.3)	118.3
	НӨАТ-т	мян.төг	410,986.5	362,181.8	227,833.7	134,348.1	62.9
	НДШ-д	мян.төг	199,445.7	133,582.2	226,603.6	(93,021.4)	169.6
6	ХХОАТ-т	мян.төг	70,000.0	85,591.5	86,175.7	(584.2)	100.7
	ҮХХАТ-т	мян.төг	9,357.4	10,000.0	9,357.4	642.6	93.6
	тээврийн хэрэгслийн татварт	мян.төг	184.7	650.0	236.9	413.1	36.4
	бусад татвар, хураамж	мян.төг	2,655.3	500.0	320.0	180.0	64.0
7	Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал	төг	0.40	0.63	0.59	0.0	94.1
8	Нийт авлага	мян.төг	136,122.4	0.0	284,290.8	(284,290.8)	
	Нийт өглөг	мян.төг	144,231.8	15,000.0	153,894.6	(138,894.6)	1,026.0
9	Үүнээс: Богино хугацаат өр төлбөр	мян.төг	36,698.9	15,000.0	46,361.7	(31,361.7)	309.1
	Үүнээс: Урт хугацаат өр төлбөр	мян.төг	107,532.9	0.0	107,532.9	(107,532.9)	
10	Хөрөнгө оруулалт	мян.төг	715,438.1	1,284,742.5	996,363.0	288,379.5	77.6
11	Ногдол ашиг	мян.төг	278,512.9	738,369.8	1,044,198.08	(305,828.3)	141.4
12	Нийт ажиллагсдын тоо	хүн	33	37	37	-	100.0
13	Нийт цалингийн сан	мян.төг	802,689.2	989,497.6	973,081.2	16,416.4	98.3
14	Нэг ажиллагчийн дундаж цалин	мян.төг	2,027.0	2,228.6	3,287.4	(1,058.8)	147.5

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Төмөр замаар тээвэрлэн нийлүүлж байгаа газрын тосны бүтээгдэхүүнийг Монголын вагон цистерн болон автоцистернд шилжүүлэн ачих, хадгалах, үйл ажиллагааг тасралтгүй явуулах, газрын тосны эх үүсвэрийг нэмэгдүүлэх, цаашид тус байгууламжийн ашиглалтыг мэргэжлийн удирдлагаар хангах” гэж тодорхойлсон байна.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Газрын тосны бүтээгдэхүүнийг шилжүүлэн ачих, хадгалах, ажлыг гүйцэтгэх;
- Газрын тосны бүтээгдэхүүнийг шилжүүлэн ачих тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллээр холбогдох байгууллагыг хангах;
- Олон улсын чанарын стандартад нийцсэн газрын тосны бүтээгдэхүүнийг зохих журмын дагуу импортлох;
- Үйлдвэрийн газар нь хөрөнгө оруулалт хийх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, судалгаа хийх;
- Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;
- Хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагаа эрхлэх.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ТӨААТҮГ статустай, Өмчийн 100.0 хувийг төр эзэмшиж байна.

Тайлант оны онцлог үйл явдлууд:

- Газрын тосны бүтээгдэхүүний 110 дээжид чанар хяналтын бүрэн шинжилгээ хийсэн;
- Өөрийн эзэмшлийн салбар төмөр замын зам арчлалтыг хариуцуулахаар тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжтэй гэрээ байгуулсан;
- Шилжүүлэн ачилтын үед 68,638.5 тонн бүтээгдэхүүнийг норматив цагт багтаан шилжүүлэн ачсан;
- Улсын төсөвт 1,044.2 сая төгрөгийн ногдол ашиг төлсөн.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ыг Засгийн газрын 2009 оны 347 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ нь төлөөлөн удирдах зөвлөлгүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд голлон мөрдөх дараах хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль;
- Төрийн хэмнэлийн тухай хууль;
- Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль;
- ЗГ-ын 2021 оны 388 дугаар “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай”;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

**Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын
2022 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Дотоод аудитын нэгж байхгүй бөгөөд тайлант хугацаанд ТӨБЗГ-ын Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсээс 2022 оны 8 дугаар сарын 29-нөөс 9 дүгээр сарын 07-ны өдрийг хүртэл тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн бөгөөд шалгалтын дүгнэлт баталгаажиж гараагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар судалж, танилцсан бөгөөд дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдэж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруултыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 525,832.6 мянган төгрөг буюу 2.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,401,789.4	4,847,081.4	3,445,292.0
Бусад санхүүгийн хөрөнгө	6,856,404.8	3,252,857.3	(3,603,547.4)
Авлага	136,122.4	284,290.8	148,168.3
Урьдчилаа	31,922.5	24,552.8	(7,369.7)
Бараа материал	260,832.2	250,925.8	(9,906.4)
Үндсэн хөрөнгө	12,667,709.2	13,214,048.0	546,338.8
Биет бус хөрөнгө	1,380,021.5	1,386,878.6	6,857.0
Нийт хөрөнгийн дун	22,734,802.0	23,260,634.7	525,832.6
Богино хугацаат өглөг	36,698.9	46,361.7	9,662.8
Үрт хугацаат өглөг	107,533.0	107,533.0	-
Эздийн өмч	22,590,570.2	23,106,740.0	516,169.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дун	22,734,802.0	23,260,634.7	525,832.6

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 4,847.0 сая төгрөг болж, 3,445.3 сая төгрөгөөр өссөн нь арилжааны банкны хадгаламжийн хугацаа дуусаж, байгууллагын харилцаад шилжүүлснээс шалтгаалсан байна.
- Бусад санхүүгийн хөрөнгө дансны үлдэгдэл 3,603.5 сая төгрөгөөр буурсан нь Голомт банкны 3,500.0 сая төгрөгийн хадгаламжийн хугацаа дуусаж харилцаад шилжүүлснээс шалтгаалсан байна. Хас банканд 252.8 сая төгрөг, Хаан банканд 1,000.0 сая төгрөг,

Төрийн банканд 2,000.0 сая төгрөг нийт 3,252.8 сая төгрөгийн хугацаатай хадгаламж байна.

- Авлага дансны үлдэгдэл 284.3 сая төгрөг болж, 148.2 сая төгрөгөөр өссөн нь ААНОАТ-ын 146.0 сая төгрөг, НӨАТ-ын 131.6 сая төгрөг, ХХОАТ-ын 6.4 сая төгрөг, бусад татварын 0.2 сая авлага байна.
- Урьдчилгаа дансны үлдэгдэл 24.6 сая төгрөгт хүрч 7.4 сая төгрөгөөр буурсан нь 2021 оны аудитын төлбөрийг 2022 онд хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой. Тэмдэг тэмдэглэгээ хийлгэх ажлын 8.6 сая төгрөг, 2022 оны аудитын ажлын 7.2 сая төгрөг, сэлбэг хэрэгсэл худалдан авахаар төлсөн 8.7 сая төгрөг урьдчилгаа төлбөрүүд байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 250.9 сая төгрөгт хүрч 9.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны зарцуулалтаас шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 13,214.0 сая төгрөгт хүрч 546.3 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:
 - Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэснээр 181.3 сая төгрөгөөр, шинээр 338.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, барилга, байгууламжийн их засварын зардал 321.8 сая төгрөгөөр, лабораторийн тоног төхөөрөмж 318.1 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2022 оны 465 дугаар тогтоолоор 24.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас баланст шилжүүлсэн, ТӨБЗГ-ын 2022 оны 713 дугаар тогтоолоор 38.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан байна. Тайлант хугацаанд үндсэн хөрөнгөд 679.9 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.
 - Биет бус хөрөнгө 6.8 сая төгрөгөөр өссөн нь газар эзэмших, ашиглах эрхийг шинээр үнэлж бүртгэснээс шалтгаалжээ.
 - Богино хугацаат өглөг дансны үлдэгдэл 46.3 сая төгрөг болж 9.7 сая төгрөгөөр өссөн нь тендерийн баталгааны барьцаа төлбөрөөс шалтгаалсан. Дээрх 46.3 сая төгрөгийн өр төлбөрийн 9.8 сая төгрөг нь цахилгааны төлбөр, 36.5 сая төгрөг нь 2022 онд тендерээр худалдан авсан үндсэн хөрөнгийн баталгаат хугацаа, барьцааны өр төлбөр байна.
 - Эздийн өмч дансны үлдэгдэл 23,106.7 сая төгрөг болж, 516.2 сая төгрөгөөр өссөн нь 253.0 сая төгрөгийн тайлант хугацааны хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, ногдол ашигийн 1,044.2 сая төгрөг, 1,307.3 сая төгрөгийн цэвэр ашигийн өсөлтөөс шалтгаалсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТУГ-ын захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 633 дугаар тогтоолоор Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТУГ-ын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 4,341.8 сая төгрөгөөр, нийт зардлыг 2,739.9 сая төгрөгөөр, цэвэр ашигийг 1,441.8 сая төгрөг байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын 23 арга хэмжээнд 1,284.7 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 3,579.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,125.0 сая төгрөгийн зардал гарган, 1,307.3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 2,125.0 сая төгрөг болж төлөвлөснөөс 761.9 сая төгрөг буюу 17.5 хувиар буурсан нь шилжүүлэн ачилтын импортын хэмжээ буурч, хадгалалтын үйл ажиллагааны гол хэрэглэгч болох "Лекс Ойл" ХХК нь ижил төрлийн үйл ажиллагаа явуулж эхэлсэнтэй холбоотой юм.

Нийт зардлын гүйцэтгэл 2,124.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 614.9 сая төгрөг буюу 22.4 хувийн дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь ажилчдад байрны хөнгөлөлт үзүүлэх 400.0 сая

төгрөг, 214.9 сая төгрөгийн удирдлагын зардлуудыг хэмнэсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 23 нэр төрлийн 20 ажилд өөрийн эх үүсвэрээс 996.4 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 1,307.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 134.5 сая төгрөгөөр дутуу байгаа нь орлогын төлөвлөгөө дутуу биелснээс шалтгаалсан байна.

ТӨБЗГ-ын 2022 оны 6 дугаар сарын 22-ний өдрийн 307 дугаар тогтоолын дагуу 2021 оны цэвэр ашгийн 40 хувь болох 1,044.2 сая төгрөгийн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Териин аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Териин аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн хөрөнгийн тооллогыг хууль тогтоомжийн дагуу чанартай гүйцэтгэх, санхүүгийн тайлангийн тодруулга, илтгэх хуудсыг бүрэн бэлтгэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Уваа уул аudit ХХК-ийн аудитор Э.Цэвээнсүрэн, Ц.Саранцэцэг, аудиторын туслах Сампилмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Ч.Мөнхтуяа хэрэгжүүлсэн.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлангаа Уваа уул Аудит ХХК-д 2023 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн 59 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 12,577.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 12.6 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоо шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Териин хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Териин хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын цахилгаан халаалтын температурыг ажлын бус цагаар багасгаж тог цахилгааныг хэмнэх зохицуулалт хийж, бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэн бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх, байгууллаас зохион байгуулах сургалт, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулах зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд авто машин худалдан авах 80.0 сая төгрөг, нэг удаагийн шагнал, дэмжлэг, урамшууллын 400.0 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой зардлаас 16.6 сая төгрөг, бичиг хэрэг, шатахууны зардлаас 20.9 сая төгрөг, дотоод албан томилолтын зардлаас 13.0 сая төгрөг, хичээл сургалтын зардлаас 5.5 сая төгрөг, нийт 536.0 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоо журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нэлөөг харгалзан 3 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ нь тайлант онд нийт 49,711.4 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 149 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу лабораторийн тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, их засвар, тавилга, компьютер техник хэрэгсэл худалдан авах тендерийг цахимаар нээлттэй, харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалт хийж, шалгарсан байгууллагуудтай гэрээ байгуулсан байна. Үүнд:

- Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээ хийх итгэмжлэгдсэн лабораторид багаж авах 315.0 сая төгрөгийн 3 тендерийг зарлан сонгон шалгаруулалт хийж, 3 аж ахуй нэгжтэй 309.0 сая төгрөгийн гэрээ байгуулан хийж гүйцэтгэсэн;
- Тээврийн хэрэгсэл авах 330.0 сая төгрөгийн 2 тендер зарлан сонгон шалгаруулалт хийж, 2 аж ахуй нэгжтэй 314.8 сая төгрөгийн гэрээ байгуулан хийж гүйцэтгэсэн;
- Компьютер, бусад тоног төхөөрөмж, тавилга эд хогшил авах 68.7 сая төгрөгийн 9 тендерийг зарлан сонгон шалгаруулалт хийж 9 аж ахуй нэгжтэй 65.9 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгэсэн;
- Төмөр замын дэвсгэр зураг шинээр зуруулах 20.0 сая төгрөгийн тендерийг шууд худалдан авалтын аргаар сонгон шалгаруулалт хийж, 1 аж ахуй нэгжтэй 10.9 сая төгрөгийн гэрээ байгуулан хийж гүйцэтгэсэн;
- Байгууламжийн 2.2 км өргөн болон нарийн царигийн төмөр замын тахир болон суман шилжүүлэг дээр бетонон дэр хийх 197.6 сая төгрөгийн тендерийг нээлттэй тендер зарлан сонгон шалгаруулалт хийж, 1 аж ахуй нэгжтэй 197.0 сая төгрөгийн гэрээ байгуулан хийж гүйцэтгэсэн;
- Их засвар, үйлчилгээ хийх 211.4 сая төгрөгийн 4 тендерийг зарлан сонгон шалгаруулалт хийж, 5 аж ахуй нэгжтэй 206.4 сая төгрөгийн гэрээ байгуулан хийж гүйцэтгэсэн байна.

Нийцсэн бөгөөд зохицой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн данс, ТБОНӨХБАҮХАТХ-ийн болон бусад холбогдох хууль эрхийн актын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрлын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрлын аудитын талаар

Завсрлын аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд нийт 1,007.9 сая төгрөгийн 5 асуудлыг илрүүлж, асуудлын бүртгэлээр зөвлөмж өгснийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 1,007.9 сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулсан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 70.5 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 116.5 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь биелэсэн байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	70,524.4	2	70,524.4	-	-	100
Албан шаардлага	3	116,500.0	3	116,500.0	-	-	100
Зөвлөмж	1	-	1	-	-	-	100
Нийт дүн	6	187,024.4	6	187,024.4	-	-	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 2¹ илэрсэнд зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 2 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын 19.0 сая төгрөгийн түвшнээс бага байгаа тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн тооллогын комиссын даргаар ерөнхий нягтлан бодогчийг томилсон, хөрөнгийн товчоо тайлан гаргаагүй, өмч хамгаалах комисс тооллогын үр дүнгийн талаарх дүгнэлт гаргаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4."комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.10 "Хуулийн этгээдийн эд хөрөнгийн тооллого, бүртгэл, ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдалд тавих дотоодын хяналт, шалгалтыг дотоод хяналтын нэгжтэй хамтран зохион байгуулж, холбогдох санал дүгнэлтээ гүйцэтгэх удирдлага, түүнчлэн эрх бүхий дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэх эрхтэй" гэж заасантай нийцэхгүй, "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн тооллогын комиссын даргаар бүртгэлээр хяналт тавьж буй ерөнхий нягтлан бодогч, нярав нарыг томилохгүй байх, өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Тодруулга тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн тодруулга, илтгэх хуудас бичээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын 6 дугаар зүйл Санхүүгийн тайлангийн тодруулга" бэлтгэх гэж заасантай нийцэхгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тодруулга, илтгэх хуудсыг холбогдох заавар, журмын дагуу бэлтгэж, санхүүгийн тайланд хавсаргаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайллангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/МЯНГАН ТӨГРӨГӨР/

Зөрчлийн товч ууга	Нийт зөрчил		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсан асуудал
	Төо	Дүн	Төо	Дүн	Албан шаардлага	Зөвлөмж	
Үндсэн хөрөнгийн тооллогын комиссын даргаар өрөнхий нягтлан бодлогийг томилсон, хөрөнгийн товчоо тайлан гаргаагүй, өмч хамгаалах комисс тооллогын үр дүнгийн талаарх дүгнэлт гаргаагүй байна.	1	-				1	-
Санхүүгийн тайллангийн тогилуулга, тодруулгын илтгэх хуудас бичээгүй байна.	1	-				1	-
<u>ДҮН</u>	2	-				2	-

Утас: +976 51 261585
Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn
Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160, Монгол Улс